БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэнгэл сумын  Ерөнхий боловсролын  2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/111/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Өлгий хот<br>2022 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954<br>Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930<br>Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Аудитор: К.Риза<br>Утас: 94156768<br>Цахим хаяг: Kalim_riza@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................................................2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................................................4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................................................5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....................................................6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....................................................6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................................................6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....................................................10
3. Аудитын тайлан....................................................10
3.1 Ерөнхий зүйл .................................................... 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .................................................... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .................................................... 11
3.4 Материаллаг байдал .................................................... 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .................................................... 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....................................................
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .................................................... 14
3.8 Аудитын гол асуудал .................................................... 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .. **Error! Bookmark not defined.**
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....................................................**Error! Bookmark not defined.**
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....................................................**Error! Bookmark not defined.**
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....................................................**Error! Bookmark not defined.**
4. Аудитын илрүүлэлт ....................................................**Error! Bookmark not defined.**
4.1 Залруулсан алдаа....................................................**Error! Bookmark not defined.**
4.2 Төлбөрийн акт....................................................**Error! Bookmark not defined.**
....................................................
4.3 Албан шаардлага ....................................................**Error! Bookmark not defined.**
4.4 Зөвлөмж ....................................................**Error! Bookmark not defined.**
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....................................................

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2022.02.25 № 143

танай ____________-ны № ______________-т

ЦЭНГЭЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
2 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Х.НАРАНЦЭЦЭГ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **13424629.00** | **14074578.00** |
| **33** | **АВЛАГА** | 4893793.00 | 1307697.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 4893793.00 | 1307697.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 8530836.00 | 12766881.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 8530836.00 | 12766881.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 562260.00 | 0.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.00 | 539000.00 |
| 35460 | Хүнсний материал | 2317800.00 | 6371200.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5650776.00 | 5856681.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1058596427.46** | **1512788431.19** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1058596427.46 | 1512788431.19 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1056198427.46 | 1510390431.19 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1106598012.20 | 1588079012.20 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -79784793.98 | -108535168.22 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 51720258.00 | 55775713.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -45500039.84 | -46972096.91 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 35042000.74 | 35042000.74 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -30810155.66 | -32294175.62 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 695071.50 | 695071.50 |
| 39217 | Ном | 18238074.50 | 18600074.50 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 2398000.00 | 2398000.00 |
| 39301 | Програм хангамж | 550000.00 | 550000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -550000.00 | -550000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2398000.00 | 2398000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1072021056.46** | **1526863009.19** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **5118287.00** | **0.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 5118287.00 | 0.00 |
| **413** | **Өглөг** | 5118287.00 | 0.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 5118287.00 | 0.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 4047287.00 | 0.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1071000.00 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1066902769.46** | **1526863009.19** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1066902769.46 | 1526863009.19 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 733123612.00 | 733123612.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 733123612.00 | 733123612.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -216332316.01 | 243627923.72 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -216332316.01 | -216332316.01 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 459960239.73 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 550111473.47 | 550111473.47 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1072021056.46** | **1526863009.19** |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **580,906,276.00** | **1,101,817,779.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **580,906,276.00** | **1,101,817,779.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 473,714,276.00 | 998,989,255.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 7,096,476.00 | 481,949,055.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 466,617,800.00 | 517,040,200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 4,610,524.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 4,610,524.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 107,192,000.00 | 98,218,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 107,192,000.00 | 98,218,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **610,535,999.89** | **641,857,539.27** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **610,535,999.89** | **641,857,539.27** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 587,710,671.89 | 625,949,047.27 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 368,711,986.00 | 411,494,496.00 |
| 210101 | Үндсэн цалин | 329,641,320.00 | 386,384,496.00 |
| 210104 | Урамшуулал | 34,416,866.00 | 21,350,157.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4,653,800.00 | 3,759,843.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49,975,000.00 | 55,067,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,167,400.00 | 38,751,300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,701,900.00 | 4,079,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,961,500.00 | 3,263,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 740,400.00 | 815,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,403,800.00 | 8,158,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 99,558,033.00 | 92,238,213.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,715,900.00 | 3,716,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 92,787,133.00 | 86,690,920.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,055,000.00 | 1,831,293.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,765,500.00 | 6,036,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 675,100.00 | 245,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 980,100.00 | 1,532,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 515,000.00 | 1,460,300.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 366,300.00 | 91,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 400,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,229,000.00 | 2,307,200.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 13,528,860.00 | 21,718,556.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 114,000.00 | 234,895.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12,021,360.00 | 20,691,611.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,393,500.00 | 792,050.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 750,000.00 | 742,900.00 |
| 210604 | Урсгал засвар | 750,000.00 | 742,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 663,000.00 | 236,300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 663,000.00 | 236,300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 375,000.00 | 598,651.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 223,651.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 375,000.00 | 375,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 50,383,292.89 | 37,816,231.27 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,890,900.00 | 6,109,780.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 48,492,392.89 | 31,706,451.27 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 22,825,328.00 | 15,908,492.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5,824,400.00 | 15,546,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 5,824,400.00 | 15,546,600.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 17,000,928.00 | 361,892.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 17,000,928.00 | 361,892.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(29,629,723.89)** | **459,960,239.73** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(29,629,723.89)** | **459,960,239.73** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **733,123,612.00** | **550,111,473.47** | **-216,332,316.01** | 1,066,902,769.46 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **733,123,612.00** | **550,111,473.47** | **-216,332,316.01** | 1,066,902,769.46 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 459,960,239.73 | 459,960,239.73 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **733,123,612.00** | **550,111,473.47** | **243,627,923.72** | 1,526,863,009.19 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **573809800.00** | **619868724.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **573809800.00** | **619868724.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 466617800.00 | 517040200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 466617800.00 | 517040200.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 4610524.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 4610524.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 107192000.00 | 98218000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 107192000.00 | 98218000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **570389800.00** | **615596724.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **570389800.00** | **615596724.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **547613972.00** | **599135346.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 369000522.00 | 407908400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 330052856.00 | 382762400.00 |
| 210104 | Урамшуулал | 34416866.00 | 21350157.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4530800.00 | 3795843.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49975000.00 | 55067600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35167400.00 | 38751300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3701900.00 | 4079100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2961500.00 | 3263300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 740400.00 | 815800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7403800.00 | 8158100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 106442000.00 | 97468000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1715900.00 | 3716000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 99671100.00 | 91697000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5055000.00 | 2055000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3654500.00 | 4670148.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 499700.00 | 193880.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 980100.00 | 1532500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 515000.00 | 1460300.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 366300.00 | 236300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 400000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1293400.00 | 847168.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 14703950.00 | 25654350.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 114000.00 | 131000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12835430.00 | 24663500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1754520.00 | 859850.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 750000.00 | 750000.00 |
| 210604 | Урсгал засвар | 750000.00 | 750000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 663000.00 | 236300.00 |
| **210702** | **Дотоод албан томилолт** | **663000.00** | **236300.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 375000.00 | 670400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 0.00 | 295400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 375000.00 | 375000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2050000.00 | 6710148.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2050000.00 | 6710148.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **22775828.00** | **16461378.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5774900.00 | 16099486.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 5774900.00 | 16099486.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 17000928.00 | 361892.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 17000928.00 | 361892.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **3420000.00** | **4272000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **3420000.00** | **4272000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3420000.00** | **4272000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 3420000.00 | 4272000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3420000.00 | 4272000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-3420000.00** | **-4272000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 0.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны** | | **Тайлант оны** | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **575349600** | **556808872** | **615258200** | **615006832** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 575349600.00 | 556808872.00 | 615258200.00 | 615006832.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 569574700.00 | 551033972.00 | 598994700.00 | 598907346.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 370185400.00 | 369000522.00 | 407908400.00 | 407908400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 331220800.00 | 330052856.00 | 382762400.00 | 382762400.00 |
| 210104 | Урамшуулал | 34426800.00 | 34416866.00 | 20608200.00 | 21350157.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4537800.00 | 4530800.00 | 4537800.00 | 3795843.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 49975000.00 | 49975000.00 | 55067600.00 | 55067600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35167400.00 | 35167400.00 | 38751300.00 | 38751300.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3701900.00 | 3701900.00 | 4079100.00 | 4079100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2961500.00 | 2961500.00 | 3263300.00 | 3263300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 740400.00 | 740400.00 | 815800.00 | 815800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7403800.00 | 7403800.00 | 8158100.00 | 8158100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 106442000.00 | 106442000.00 | 97468000.00 | 97468000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1715900.00 | 1715900.00 | 3716000.00 | 3716000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 99671100.00 | 99671100.00 | 91697000.00 | 91697000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5055000.00 | 5055000.00 | 2055000.00 | 2055000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 10648400.00 | 3734500.00 | 3635000.00 | 3587568.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 559600.00 | 499700.00 | 206800.00 | 193800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1225000.00 | 980100.00 | 1225000.00 | 1225000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 917200.00 | 595000.00 | 985300.00 | 985300.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 407000.00 | 366300.00 | 295400.00 | 236300.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 236200.00 | | | 200000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7303400.00 | 1293400.00 | 922500.00 | 747168.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 21357600.00 | 14703950.00 | 25667600.00 | 25654350.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 153800.00 | 114000.00 | 131000.00 | 131000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12850600.00 | 12835430.00 | 24668400.00 | 24663500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 8353200.00 | 1754520.00 | 868200.00 | 859850.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 750000.00 | 750000.00 | 750000.00 | 750000.00 |
| 210604 | Урсгал засвар | 750000.00 | 750000.00 | 750000.00 | 750000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 763100.00 | 663000.00 | 236300.00 | 236300.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 763100.00 | 663000.00 | 236300.00 | 236300.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 857000.00 | 375000.00 | 695400.00 | 670400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 407000.00 | | 295400.00 | 295400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450000.00 | 375000.00 | 400000.00 | 375000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 8596200.00 | 5390000.00 | 7566400.00 | 7564728.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8596200.00 | 5390000.00 | 7566400.00 | 7564728.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 5774900.00 | 5774900.00 | 16263500.00 | 16099486.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 5774900.00 | 5774900.00 | 16263500.00 | 16099486.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 5774900.00 | 5774900.00 | 16263500.00 | 16099486.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **573809800** | **573809800** | **615258200** | **615006832** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 466617800.00 | 466617800.00 | 517040200.00 | 516788832.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 466617800.00 | 466617800.00 | 517040200.00 | 516788832.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 107192000.00 | 107192000.00 | 98218000.00 | 98218000.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 107192000.00 | 107192000.00 | 98218000.00 | 98218000.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 36.00 | 36.00 | 36.00 | 36.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 2.0 | 2.0 | 2.0 | 2.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 17.0 | 17.0 | 17.0 | 17.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16.0 | 16.0 | 16.0 | 16.0 |
| 620004 | Гэрээт ажилтан | 1.0 | 1.0 | 1.0 | 1.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **0.00** | **4500000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **0.00** | **3040000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 3040000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 1050000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 575000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 475000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 0.00 | 1400000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 1400000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 0.00 | 590000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 590000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **1460000.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 0.00 | 1460000.00 |
| 225001 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 1460000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 0.00 | 4500000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.00 | 4500000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 4500000.00 |

3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Цэнгэл сумын  Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь  Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, гэрээт аудитор К.Риза нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь  Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн №03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Цэнгэл сумын  Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн эрхэм зорилго нь “Суралцагчдын хэрэгцээнд суурилсан хүртээмжтэй, сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан зөв хандлага төлөвшилтэй, бүтээлч, бие даан сурах хүсэл тэмүүлэлтэй болгон хүүхдэд  сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмшүүлэх  бэлтгэхэд оршино ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй  байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд тус сургуулийн  үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй  гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл  дунд  гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020  оны нийт зардал  610.5 сая төгрөгийн 2 хувиар буюу 12.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 9.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох  шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 454.8 сая төгрөгөөр буюу 42.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 4893.8 | 1307.7 | (3587.1) |
| Бараа материал | 8530.8 | 12766.9 | 4236.1 |
| Үндсэн хөрөнгө | 1058596.4 | 1512788.4 | 454192.0 |
| **Нийт хөрөнгө** | **1072021.0** | **1526863.0** | **454842.0** |
| Өр төлбөр | 5118.3 | | (5118.3) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1066902.8 | 1526863.0 | 459960.2 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1072021.0** | **1526863.0** | **454842.0** |

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн болон эцэст үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн татварт 4.9 сая төгрөгийн авлагатай байсан ба оны эцэст 1.3 сая төгрөг болж оны эхнээс 3.6 сая төгрөгөөр буурсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 12.7 сая төгрөг болж оны эхнээс 4.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хүнсний материал 4.1 сая төгрөгөөр, түлшний үлдэгдэл 0.5 сая төгрөгөөр, бусад хангамжийн материалын үлдэгдэл 0.3 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 0.2 сая төгрөгийн эм боох материал, 5.6 сая төгрөгийн аж ахуйн материал, 2.4 сая төгрөгийн түлш шатахуун, 24.2 сая төгрөгийн хүнсний материал, 0.7 сая төгрөгийн барилга засварын материал, нийтдээ 33.0 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан ба 0.3 сая төгрөгийн аж ахуйн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээж авч нийтдээ 33.3 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч, 29.1 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зохих зарлагын баримтуудыг үндэслэн зарцуулсан байна.

Төсвийн хөрөнгөөр тайлант онд 3.9 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 0.4 сая төгрөгийн ном нийтдээ 4,3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан ба Туркийн Засгийн газрын “ТИКА” төслийн хүрээнд 481.5 сая төгрөгийн өртөг бүхий 29 хүүхдийн багтаамжтай дотуур байр, 0.1 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Боловсролын газраас үнэ төлбөргүй хүлээн авч үндсэн хөрөнгийн тайлант оны 31.7 сая төгрөгийн элэгдлийн зардлын дүнгийн зөрүүгээр оны эхнээс 454.2 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Оны эхэнд 5.1 сая төгрөгийн татвар болон бараа үйлчилгээний зардлын өртэй байсныг тайлант онд бүрэн барагдуулж оны эцэст өр төлбөргүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 460.0 сая төгрөгөөр өссөн нь тухайн жилд хүлээж авсан хөрөнгийн санхүүжилт, тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 89.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд тус сургуульд 481.9 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт хийгдсэн болон урсгал зардлын санхүүжилтийн хэмжээ өмнөх оноос өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос нийт дүнгээр 31.4 сая төгрөгөөр өссөн нь урьд оноос цалин нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 56.8 сая төгрөгөөр, хоол, үдийн цайны зардал 8.6-9.6 сая төгрөгөөр өсөж, халаалтын зардал 6.1 сая төгрөгөөр буурсан болон бусад бараа үйлчилгээний зардлуудын өсөлт, бууралт нөлөөлжээ.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны төсвийг Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 16 дугаар тогтоолоор 571.9 сая төгрөгөөр баталжээ.

Нийт төсвийн 476.9 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 95.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 41 дүгээр тогтоолоор баталсан төсвийн тодотголоор цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 41.4 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 2.0 сая төгрөгөөр, хичээл үйлдвэрлэлийн зардлыг 5.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нормативт зардлыг 1.0 сая төгрөгөөр ,төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлын төсвийг 4.0 сая төгрөгөөр бууруулж тодотгон тусгай зориулалтын дэмжлэгээс авах санхүүжилтийн хэмжээг 40.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт төсвийг 615.0 сая төгрөгөөр баталсан байна.

Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал нэмэгдсэн нь анх баталсан төсөвт дутуу суулгасантай холбоотой байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 516,8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 98,2 сая төгрөгийн нийтдээ 615.0 сая төгрөгийн санхүүжилтээр батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулж, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл болох 0,4 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 614.9 сая төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Нийт төсвийн 75,2 хувийг цалин, НДШ-ийн зардал, 15,8 хувийг тогтмол зардал, 0.6 хувийг хангамж бараа материалын зардал, 4.2 хувийг норматив зардал, 4.2 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд Аймгийн Боловсролын газраас 4.6 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон ба 1.4 сая төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авч, 1.4 сая төгрөгийг төслийн хүрээнд явагдсан сургалтын төлбөрт төлж, 1.6 сая төгрөгийг бичиг хэрэг, бараа

үйлчилгээний зардалд зарцуулан зарцуулагдаагүй үлдэгдэл 0.1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

Байгууллагын сургалтын үйл ажиллагаа ковидтой холбоотойгоор танхимаар болон цахимаар явагдаж ирсэн ба байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн горим сорилын дүнгээр үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлуудад цалингийн зардалд 407.9 сая төгрөг, НДШ-ийн зардалд 55.0 сая төгрөг, байр ашиглалтын зардалд 97.5 сая төгрөг, хүүхдийн хоолны зардалд 24.7 сая төгрөг, үдийн цайны зардалд 16.1 сая төгрөг нийтдээ 601.2 сая төгрөг зарцуулсан байна.

Тус сургуулийн нийт санхүүжилт 614.9 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай 601.2 сая төгрөгийн зардлыг хасаж 13.7 сая төгрөгийг тэвчиж болох зардал гэж үзээд Засгийн газрын тогтоолын дагуу уг зардлын 10 хувь болох 1.4 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба тус байгууллага нь оны эцэст 0.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн боловч Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс 1.0 сая төгрөгийн хэмнэлт дутуу гаргасан байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 117 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр өр, авлага үүссэн талаархи 10.0 сая төгрөгийн мэдээллийг, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 83.3% -тай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгээр мэдээлбэл зохих мэдээллүүдээс 3 мэдээллийг байршуулаагүй зөрчилд зөвлөмж өгсөн ба биелэлтийг ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн мөрөөр хийсэн ажлын тайланг шилэн дансанд байршуулсан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 24.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 2.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 20.6 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар 2.6 сая төгрөгийн зөрчилд төлбөр барагдуулах акт тогтоолоо. Үүнд:

1.Тайлант онд цалингаас нийтдээ 27.8 сая төгрөгийн татвар суутган авч 25.2 сая төгрөгийг төсөвт төлж, 2.7 сая төгрөгийн татварыг төсөвт дутуу төвлөрүүлж, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүй байсныг төсөвт нөхөн төлүүлэхээр акт тогтоов.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн 14.4.1 , 14.4.2, ХХОАТ-ын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.1, Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт дутуу төвлөрүүлсэн 2.6 сая төгрөгийн татварыг төсөвт нөхөн төлүүлэх акт тогтоов.

**4.3 Албан шаардлага**

Аудитаар 1.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь 2021 онд гүйцэтгэлээр 614.9 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 14.0 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувь 1.4 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүйгээс оны эцэст 0.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, 1.0 төгрөгийг дутуу төвлөрүүлжээ.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тэвчиж болох зардлаас хэмнэлт гаргаагүй 1.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1.*** **Тайлагналтай холбоотой асуудал**

*1.1. Илрүүлэлт:*
Үдийн цай, тээвэр шатахуун, халаалт, гэрэл цахилгааны зардлаас нийтдээ 10.6 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*
Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2,14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 дэхь заалтуудыг мөрдөж, үдийн цай, тээвэр шатахуун, халаалт, гэрэл цахилгааны зардлуудын гүйлгээг өглөг дансаар дамжуулан тооцоо үүсгэж, бүртгэж тайлагнах, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах.

**2. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:
Тайлант оны шилэн дансны мэдээллийг шалгахад 10.0 сая төгрөгийн өр, авлага үүссэн 2 мэдээлэл, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 83.3 хувьтай байна.

2.2. Өгсөн зөвлөмж:
Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл** /сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Цэнгэл сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль | 4 | 24.3 | | | 1 | 2.7 | 1 | 1.0 | 2 | 20.6 |